



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 237.

Улаанбаатар хот

“Монгол ус” төрийн өмчит үйлдвэрийн
газрын 2020 оны эдийн засгийн үндсэн
үзүүлэлт, зорилтот түвшин болон контрактын
биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон захирал Г.Билэгсайхантай байгуулсан 2020 оны контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Монгол ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Билэгсайхантай байгуулах контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу 1 жилийн хугацаатай шинэчлэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

13201005

ТӨБЗГ тогтоол-/2021